

БӨХХИШИГИЙН ТУХАЙ СУДАЛГААНЫ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ТООЧИЛ

Сэцэн*

Хан Сарнай**

Боо Йин***

* Өвөр Монголын Их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн Сонин мэдээлэл, хэвлэхүй ухааны салбарын доктор, профессор

** Өвөр Монголын Их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн Монгол хэвлэхүй түүхийн судалгааны чиглэлт аспирант

*** Өвөр Монголын Үндэстний их сургуулийн Хэвлэл мэдээллийн дээд сургуулийн багш

Хөрвүүлсэн: Л.Норовсүрэн

Түлхүүр үг: Бөххишиг, судалгааны байдал, амжилт, алдагдал, орон зай.

Агуулгын товч: Орчин үеийн монгол хэвлэхүй үйлсийн зүтгэлтэн Бөххишигийн тухай судалгааг 1964 онд монголч эрдэмтэн Вальтер Хайссиг авгай улсын гадаадад эхлүүлсэн ба Б.Гэрэлт профессор 1981 онд улсын дотоод дахь судалгааны хөшгийг ярнаас одоо болтол 16 тусгай сэдэвт өгүүлэл, 2 тусгай бүтээл нийтлэгдэн хэвлэгдэв. Сүүлийн үед хэвлэгдсэн нэвтэрхий толь, нэвтэрхий түүх хийгээд намтар тэмдэглэл, орон нутгийн ойллогод ч өдий төдий танилцуулга нийтлэгдсэн байдаг. Бидний өнгөрсөн судалгааны бүтээлийг он дараалан сөхөн ажигласнаар Бөххишигийн тухай судалгааны олон хараашаас нилээд эрчимтэй явагдсан боловч голдуу утга зохиолын хүрээнд төвлөрч, бусад талаас бол намтарчлан танилцуулсан төдий анхан шатны байдал тодруулалтад зогсонгуйрсаар байна.

Бөххишиг насан туршид олон хүрээнд эрчимтэй ажиллав. Түүний үйл

ажиллагаанд хамгийн чухал бөгөөд ил бодитой харагдах монгол утгын сургаалын хурлыг үүсгэн байгуулсан хийгээд "Улаан барс"-ыг эрхлэн найруулсан мэтийн орчин үеийн монгол найруулахуй хэвлэхүй үйлсэд үзүүлсэн гавьяа зүтгэлийг нь бүрэн гүйцэд тодруулаагүй байна. Үүнээс гадна хамагчилсан нарийн асуудал дээр дам материалд үндэслэснээс болсон эндүү тодорхойлолт ч харагдана. Иймээс шинжилгээний салааны арга онол хийгээд анхдагч материалд суурилсан бөгөөд орчин үеийн үзэл урсгалын их орчинтой нь холбож задалсан нарийсгасан судалгааг шалбадан хийгүүштэй байна гэдэг үзэлтээ дэвшүүлжээ.

Бөххишиг бол монгол үндэстний орчин үеийн үзэл санаа, утга зохиол, сурган хүмүүжил хийгээд найруулахуй хэвлэхүйн түүхнээ нөлөө ихтэй соёлын зүтгэлтэн болно. XX зууны хориод онд "Утга соёлоор үндэстнээ тэтгэн тэнхрүүлэх" зорилтоор Бөххишиг "Монгол утгын сургаалын хурал" гэх соёлын нийгэмлэгийг үүсгэн байгуулсан ба "Улаан барс"-ыг эрхлэн найруулжээ. Түүгээрээ тавцан болгон олон арван

ажиллагаа өрнүүлж, монгол үндэстний утга соёл, сурган хүмүүжил ба найруулахуй хэвлэхүй үйлсэд насан туршид мэрийн зүтгэж баларшгүй хүчин зүтгэлээ нэмэрлэсэн юм. Бөххишиг хүний ертөнцөд дөчин хоёрхон хавар, намрыг өнгөрүүлсэн боловч хязгаартай нэг насаа хязгааргүй монгол соёлын ариун дархан үйлсэд зориулсан юм.

Нэг. Бөххишигийн тухай судалгаа улсын гадаадад эхэлсэн нь

Бөххишигийн тухай судалгааны анхны хуудсыг бичиглэсэн хүн бол баруун Германы Боннын Их сургуулийн профессор Вальтер Хайссиг авгай болно. Тэрбээр 1964 онд "Монголын түүх ба соёл" [1] гэх номоо герман хэлээр хэвлүүлжээ. Тус номын нэгдүгээр бүлэг ба есдүгээр бүлэгт "Зүүн Монголын утга зохиолын хороо"-ноос хэвлэсэн Инжиннашийн "Хөх судар" ба Бөххишигийн нас нөгчсөн тухай, тус хурлаас хэвлэсэн "Хөх судар" нь Тэмгэтийн хэвлүүлснийг бодвол тайлбар сэлт нь оновчлог бөгөөд бүрэн болсон ба Бөххишигийн Японд сэжиглэгдэн хорлогдсон явдал зэргийг холбогдуулан өгүүлжээ. Тэрээр Бөххишигийг "Монголын соёл ба үндэстнийг хамгаалагч", "Монголчуудын бие даасан утга зохиолын чин зоригт хамгаалагч", "Монголын хэвлэлийн хороог зохион бүтээгч" гэж үнэлсэн байна [1:23]. Тэрээр бас Бөххишигийн нас нөгчсөн тухай "1943 онд монгол утга зохиолыг хамгаалагч Бөххишиг гэнэт нас барсныг Монголын өдрийн сонин мэдээлэв. Япончууд Бөххишигийг алах ялаар шийдвэрлэсэн гэдгийг дайны дараа Америкийн хэвлэлийн газрын мэдээлснээр тодорхой болов" [1:276] гэх сураг зангийг хангав. Вальтер Хайссигийн энэхүү үзэлт нь сүүлийн үеийн эрдэмтдийн Бөххишигийн нас барсан тухай тайлбарласан өгүүлэл, зохиолд олон-таа ишлэгдсээр буй. Үүнээс гадна Вальтер Хайссигийн өөрийн сүүдэрлэсэн Бөххишиг авгайн 1941 оны нэг хувь

сүүдрийг тус номдоо дагалдуулан хэвлэсэн [1:24] нь ховор нандин түүх материал болжээ.

Вальтер Хайссиг авгайн хангасан Бөххишиг хийгээд монгол утгын сургаалын хурлын тухай сураг занги нь XX зууны наяд оноос эхэлсэн улсын дотоодын эрдэмтдийн судалгаанд суурь-чулуу болсон байна.

Хоёр. Бөххишигийн тухай судалгаа улсын дотоодод дэлгэрсэн нь

1. XX зууны наяд оны намтарчилсан танилцуулга

Улсын дотоодод Бөххишигийн тухай судалгааг эхлүүлсэн хүн бол профессор Б.Гэрэлт болно. Тэрбээр 1981 оны "Монгол зохиолчдын шүүмж өгүүллүүд (1721-1945)" [2] гэх номдоо Бөххишигийн "Монголын язгуурын түүхийн оршил" ба "Зохион бичих тухай захидал" гэх хоёр зохиолыг нь танилцуулжээ.

Тус танилцуулгынхаа зүүлтэд Бөххишиг "нийгмийн хүчнийг түшиглэж, найр танил халуун сэтгэлтэн хүмүүсийн мөнгө зоосны тусламжаар монгол утгын сургаалын хурлыг эрхэлж байсан" гэсэн ба тус хурлаас хэвлүүлсэн ном зохиол ба "Улаан барс"-ыг Бээжингээс Хайлу-д шилжүүлэн авчирч үргэлжлүүлэн гаргаж байсан тухай цухас дурдаж, Бөххишигийг "Монгол үндэстний соёл гэгээрлийн үйлсэд чухал зүтгэл үзүүлэгч" [2:353] гэж үнэлэв. Иймээс Б.Гэрэлт профессор бол Бөххишиг судлалын улсын дотоод дахь анхны хөшгийг ярагч болно. Мөн жилд ахмад эрдэмтэн Эрдэнэтогтох "Бөххишиг хийгээд монгол утгын сургаалын хурал" [3] гэх өгүүллээ нийтлүүлж, Бөххишигийн амьдрал үйлс ба монгол утгын сургаалын хурлаас хэвлүүлсэн есөн ном зохиол хийгээд Бөххишигийн өөрийнх нь зургаан ном зохиолын тухай нарийн танилцуулжээ.

Тэрээр бас 1983 онд "Монгол үндэстний сурган хүмүүжлийн бичиг материалын эмхтгэл" [4]-ээ хэвлүүлж,

Хээшингэ, Ролгаржав, Бөххишиг бол хуучин Дундад улсын Өвөр Монголын ном хэвлэлийн ажлын ууган зүтгэлтэн нар мөн" [4:2] гэв. Тусгай бүлгээр Бөххишигийн амьдрал үйлс хийгээд зохиол бүтээлийг нарийн танилцуулаад "Бөххишиг бол хуучин Дундад улсын үеийн ном хэвлэлийн ажлыг эрхэмлэн ахиулж байсан дэвшилт дээд сэхээтний төлөөлөгчдийн нэг болж болно" [4:2] гэв. Тус бүтээлд Бөххишигийн "Улаан барс" сэтгүүлийн оршил, "Хурлын гишүүдэд өгсөн захидал", "Монгол утгын сургаалын хурлын хураангуй дүрэм", "Дагалдуулан мэдэгдэх зүйл" зэрэг хурал байгуулж сэтгүүл эрхэлсэн үзэл бодлыг тусгасан зохиолыг нь дагалдуулан хэвлүүлжээ. Иймээс Эрдэнэтогтох гуай бол Бөххишигийн тухай хамгийн бүрэн, нарийн, найдвартай танилцуулгыг анхлан хийсэн хүн болно.

1984 онд Б.Сэцэнбаатар "Монгол үндэстний түүхэн дэх соёлын зүтгэлтэн Бөххишиг хийгээд түүний соёлын ажиллагаа" [5] гэх ганц сэдэвт зохиолоо нийтлүүлж, Бөххишигийн амьдрал, ажил үйлс хийгээд түүний эрхэлсэн монгол утгын сургаалын хурал ба "Улаан барс"-ын шинж чанарын тухай: "Монгол утгын сургаалын хурал" бол монгол хэл, утга зохиолын эрдэм шинжилгээний нийгэмлэгийн чанартай байгууламж болно. Түүний эрхэлж байсан "Монгол утгын сургаалын хурал"-аас "Улаан барс" хэмээх эрдэм шинжилгээний сэтгүүл эрхэлж байлаа" [5] гэж монгол утгын сургаалын хурлыг эрдэм шинжилгээний нийгэмлэг "Улаан барс"-ыг эрдэм шинжилгээний сэтгүүл гэв.

Б. Гэрэлт профессор 1985 онд хэвлүүлсэн "Монгол зохиолын онолын чимэг" [6] гэх номынхоо "Орчин цагийн хэвлэлийн үйлс ба монгол зохиолын судалгааны ажил" "Авчрах ухамсар"-ыг шинжиж: "Япон улсын сургуулийг тойрон үзсэн өдрийн тэмдэгдэл"-д нь тухайн үеийн Япон улсын давшсан сурган хүмүүж-

лийн төлөв байдлыг бүх талаар нарийн хянамгайгаар тэмдэглэж, Японы сургууль соёл эрхэлж байгаа давшингуй талыг угсаа үндэстэндээ шингээн авахыг зорьсон байна" [18] гэж дүгнэжээ. "Бөххишиг хийгээд түүний сурган хүмүүжлийн тухай үзэлт үйлдэлгэ" гэх өгүүлэлдээ Бөххишигийн сурган хүмүүжлийн талаар өрнүүлсэн ажил үйлсийг хураангуйлан тоочиж Бөххишигийн зүтгэл нь "Орчин үеийн үндэстний хэвлэлийн үйлсэд товойн илэрч байгаагаар үл барам сурган хүмүүжлийн үйлсэд ч илтэд харагдаж байдаг" [19] гэж Бөххишигийн сурган хүмүүжлийн үйлс дэх гавьяа зүтгэлийг нь дахин тодруулав.

«"Улаан барс" сэтгүүл хийгээд монгол хэл бичиг» гэх өгүүлэлдээ "Улаан барс" дахь монгол хэл бичгийн тухай ухуулга сурталчилгааг танилцуулан Бөххишигийн "Улаан барс" сэтгүүлээр дамжуулж өрнүүлж байсан монгол хэл бичгийн эрдэм шинжилгээний бодитой ажлыг шинэ нэр томьёог орчуулан дүрэмжүүлж тогтоох, монгол хэлний авиаг хятад үсэг дээр тэмдэглэхийг дүрэмжүүлэх, нутгийн аялгууны үгсийг утга зохиолын хэлэнд шингээн авах, "Улаан барс" сэтгүүлд орчуулгын эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэх, эртний монгол үсэг бичгийн тухай танилцуулга хийх зэрэг талаар зурвасчлан тодруулжээ [20]. "Бөххишиг, Ролгоржавын "Монгол хятад аялгууг хосолсон бичиг"-ийн тухай" гэх өгүүлэлдээ "Монгол хэлний авиаг хятад үсгээр хэрхэн тэмдэглэх асуудал бол түүхэн турш оршсоор ирсэн эрдэм шинжилгээний асуудал болох ба оmtгойлж үл болох нийгмийн асуудал мөн. Бөххишиг, Ролгоржав нар тус зууны гучаад оны үед энэхүү асуудлыг сэрэн мэдэж, шийдвэрлэх анхны алхмыг алхсан нь туйлын чухал ач холбогдолтой юм" [21] гэж маш бодисчоор үнэлэн "Улаан барс"-ын монгол хэл бичгийн ажил дахь ахуйч ач холбогдлыг нь тодорхойлжээ. "Хорчины орчин үеийн бичгийн зохиол хийгээд Кайлу-

гийн монгол утгын сургаалын хурал" гэх өгүүлэлдээ Кайлугийн монгол утгын сургаалын хурлаас утга зохиолын ажлаа эрчимтэй хөгжүүлэхийн төлөө авч байсан арга авцыг "Кайлугийн монгол утгын сургаалын хурал нь "Улаан барс" сэтгүүлийг эрхлэн олон тооны бичиг зохиолыг цугларуулан нийтэлснээр үл барам монгол ном бичгийг хэвлүүлэн, Хорчины орчин үеийн бичгийн зохиолыг хөгжүүлжээ" [22] гэж орон нутгийн уран зохиолын үйлс дэх гавьяа зүтгэлийг нь тодруулав.

2. XX зууны 90-ээд оны тусгай сэдэвт зохиол бүтээл

1992 он бол Бөххишигийн мэндэлсэн 90 жилийн ой болно. Тус жилд Эрдэмт ба Буянтогтох хоёул хамтран найруулсан "Бөххишиг хийгээд түүний монгол утгын сургаалын хурал" [23] гэх ном хэвлэгдэв. Тус ном нь Бөххишигийн тухай судалгааны анхны тусгай бүтээл болно. Тэд Бөххишигийн уул нутагт хүрч, ахмад настныг сурвалжилсан ба тэднүүсийн эргэцүүлэлд түшиглэн Бөххишигийн намтар түүхийн хамаатай зарим мадагтай асуудлыг зохистой шийдвэрлэжээ. Жишээлбэл: үүнээс өмнөх судалгаанд Бөххишигийн төрсөн нутгийг Найман хошууны "Бэхи ус" [3], "Бөх ус" [24], "Бэх ус" [10:402] гэж адил бусаар тэмдэглэж байсан бол тус бүтээлд энэ айлын нутаг усны ирэлтийн тухай хоёр домгоор үндэслэл болгож "Бэх ус" хэмээн тодолосон байна. Тус бүтээл дэх Бөххишигийн намтар танилцуулга нь үүнээс өмнөх судалгааг бодвол маш нарийн оновчтой бөгөөд системтэй болжээ. "Бөххишигийн зохиол бүтээл" гэх хэсэгтээ Бөххишигийн "Япон улсын сургуулийг тойрон үзсэн өдөр бүрийн тэмдэглэл" зэрэг 4 зохиол бүтээл ба түүний нас нөгчсөн тухай холбогдол бүхий бичиг материал зэргийг уул хэвээр нь сийрүүлэн хэвлүүлж, уншигч судлагчдын судлан ашиглахад анхдагч материалыг хангасан байна. "Бөххишигийн

байгуулсан "Монгол утгын сургаалын хурал" ба "Улаан барс" сэтгүүлийн ажил" гэх хоёр хэсэгтээ "Хурлын хүрээ", "Хурлын хураангуй дүрэм", "Удирдагч багш нарын алдар нэр", "Хурлын гишүүдийн нэрийн илтгэл" зэргийг танилцуулж, эдгээр бодит материалд суурилан монгол утгын сургаалын хурал ба "Улаан барс" сэтгүүлийн эзэгнэлтийн байдлыг нилээд нарийн тусгажээ. Тус бүтээлд бас монгол утгын сургаалын хурлаас хэвлүүлэн тархаасан нийт "Дөчөөд зүйлийн монгол ном бичиг" [23:80]-ийн доторх 25 зүйлийн номыг гарчиглан тодруулж жагсаасан нь өнгөрсний судалгаанд хийсэн чухал нөхвөр болоод зогсохгүй, хожмын судалгаанд материал хангав.

Н. Алтаншаа бээр 1993 онд "Монголчуудын өчигдрийн мөр" [25] гэх номоо найруулан хэвлүүлж, Бөххишигийн амьдрал үйлсийг "Тэр бол манай монгол үндэстний орчин үеийн алдарт сэтгүүлч, найруулагч, хэвлэгч болохоор үл барам бас сурган хүмүүжүүлэгч болдог юмсан" гэж Бөххишигийн зүтгэлд найруулах, хэвлэх үйлс дэх гавьяа зүтгэл нь гол болж, сурган хүмүүжлийн үйлс дэх гавьяа зүтгэл нь татална [25:1495] гэдэг зүйтэй үзэлтийг дэвшүүлэв. 1996 онд Вэн Мандаа бээр "Монгол уран зохиолын онол шүүмжлэлийн түүхэн найруулал (X-XX зууны эх)" [26] гэх номоо хэвлүүлж Бөххишигийн бичсэн оршил гаргалгын зохиолоос түүний үзэлт зорилтод үндэстний уран зохиолын хэлээ хөгжүүлэх асуудлыг чухалчлах, уран зохиолын танин мэдэхүй, сурган хүмүүжүүлэх, зугаа цэнгэлийн үйлдлийг гүнзгий ухаарч байсан, өөрийн үндэстний уран зохиолын уламжлалаар гол үндэс болгох, харь үндэстний уран зохиолын шилдэг сайн содон зүйлийг шингээн авч ашиглахыг зорьж байсан зэрэг талаар сүвэгчлэл хийжээ. 1997 онд Ононзаяадай бээр "Түүхэн дэх монгол үндэстний цуут хүмүүс" [27] гэх бүтээлээ хэвлүүлж,

монгол утгын сургаалын хурлаас хэвлүүлсэн 11 ном зохиол ба Бөххишигийн өөрийнх нь ном зохиолыг танилцуулаад, Бөххишигийг "Соёл, хэвлэлийн үйлсийн дайчлагч" [27:300] гэж үнэлжээ. 1999 онд Төгсцогт, Вэн Сиү Лэн-ий хамтран туурвисан "Монгол сонин сэтгүүлийн түүхэн тойм" [28] гэх бүтээлд "Орлого зарлагын нарийн тооцоог сэтгүүлийн хуудсанд нийтэлж аж ахуйн ажлыг ил болгохоор зорьсон ба нэр томъёог тогтворжуулан хичээл хүмүүжил, эрдэм шинжилгээнд суурь тавин өгсөн хийгээд сэтгүүлийн хавтсаа гоц урласан" зэрэг жишээгээр Бөххишигийн "Улаан барс" сэтгүүлийг эрчимтэй эрхэлж байсан байдлыг сэтгүүл зүйн үүднээс судалж тодруулав. Тэд тус сэтгүүлийн онцлогийг хураангуйлахдаа "Хэлэлгээнгүй орчин үеийн сонин сэтгүүлийн дотор хувь хүний эрхэлсэн хэвлэгдэхүүн гэвэл ганц "Улаан барс"-аар зогсохгүй юм. Гэхдээ хавьцаагаар өргөн, хэвлэгдсэн цаг нь урт, ялангуяа нөлөө ихтэй нь хааш л "Улаан барс" болох юм" [28:294] гэж бусад сэтгүүлтэй харьцуулан үнэлэлт хийсэн нь судалгааны үнэ өртөгтэй болов:

Ү. Шугарын 2000 онд нийтлэгдсэн "Монгол шинэ соёлын зүтгэлтэн Бөххишиг" [29] гэх тусгай сэдэвт өгүүлэлд "Япон улсын сургуулийг тойрон үзсэн өдөр бүрийн тэмдэглэл"-ийн агуулга, үндсэн утга санаа, урлагийн онцлогийг нь утга зохиолын онолоор задлан шүүмжлээд Бөххишигийн энэхүү өдрийн тэмдэглэлийг "Монгол уран зохиолын түүхэнд анхдагч өдрийн тэмдэглэлийн хэлбэр бүхий найруулал" [29] гэжээ.

3. Шинэ зуун дахь шинэ сэдэвт зохиол бүтээл

2002 онд хэвлэгдсэн Бүрээчин дарханы "Дундад улсын сонин мэдээний түүхэн тойм" гэх номд "Улаан барс" сэтгүүлийг танилцуулахдаа "Ү.Бөххишиг бол Монголын орчин үеийн их бичгийн хүн, монгол бар хэвлэлийн

алдарт зүтгэлтэн, нэрт сэтгүүлч мөн" [30:215-216] гэж Бөххишиг авгайн монгол хэвлэлийн үйлсэд үзүүлсэн гавьяа зүтгэлийг өндөр үнэлсэн байна. Мөн жилд Б.Мөнх, Ган Шан бээр "Улаан барс" сэтгүүл хийгээд түүний монгол ардын дууны цуглуулга" [31] гэх өгүүлэл нийтлүүлжээ. Зохиогчоос "Монгол утгын сургаалын хурал"-ын цол эрдэм шинжилгээний шинж бүхий нийгэмлэг болохыг чухалчлахын дагуу монгол ардын дуу цуглуулах явдал нь монгол зан үйлийн ухааны судалгааны ажил, жич бүхүйлэн монгол соёлыг хөгжүүлэх ажилд суурь тавьж, нөхцөл бүрэлдүүлсэн байна гэж үзжээ.

2003 оны 10 дугаар сард Б.Сүхээ гуай бээр "Бөххишиг хийгээд "Улаан барс" сэтгүүлийн судлал" [33] гэх тусгай бүтээлээ хэвлүүлсэн байна. Тус бүтээл бол Бөххишигийн тухай хоёр дахь тусгай бүтээл болно. Тэрээр "Улаан барс" сэтгүүлийн хамгийн баялаг материалыг хадгалагчийн хувиар 4 дүгээр хугацаа 5, 6, 9, 10 дугаар хугацааны 1-12 дугаар тэмдэг хүртэлх [32:23] анхдагч материалд суурилан найдвартай судалгаа хийжээ. Үүнд голдуу "Улаан барс" сэтгүүлд нийтлэгдсэн монгол хэл бичгийг сурч, хэрэглэх тухай ухуулал сурталчилгаа ба монгол хэл бичгийн эрдэм шинжилгээний ажил, ардын дуу, хуримын ёсон хийгээд хуримын хэл мөр, хавт үг, "Монгол-хятад аялгууг хосолсон бичиг", эрүүл мэндийн хүмүүжил, жич Бөххишигийн сурган хүмүүжлийн тухай үзэлт, үйлдлэгийг танилцуулахаар дамжуулж, Бөххишигийн монгол хэл бичгийн үйлс, зан үйлийн судалгаа, эрүүл мэндийн хүмүүжлийн үйлс ба сурган хүмүүжлийн үйлсэд үзүүлсэн нэмэр хандивыг тодорхойлж, Бөххишигийн тухай судалгааг нэг өргөн хүрээнд дэлгэсэн байна. Мөн жилд нийтлэгдсэн аспирант Улааны "Бөххишигийн утга соёлоор угсаа үндэстнээ сэнхрүүлэх үзэлтийг дурсан өгүүлэх нь" [33] гэх өгүүлэлд Бөххишигийн утга соёлоор угсаа үндэстнээ сэнхрүүлэх

үзлийг өгүүлэхдээ Бөххишиг “Муугаар сайныг” өдөөн гаргаж утга зохиолын үзэлт, “үзэх бүхнийг багад оруулах” яруу найргийн зохион бүтээлчийн зарчим, “утга зохиол нийлэлцэх” яруу найргийн үзлийг санаачилж байсан гэж дурджээ. Мөн жилийн 12 дугаар сард бас профессор Б.Гэрэлтийн шүүмжлэн тайлбарласан “Монгол зохиолын онол өгүүлэхүйн өв шүүлт” [34] гэх бүтээл хэвлэгдэж зохиогчийн “Монгол зохиолчдын шүүмжүүд (1721-1945)” гэх бүтээлдээ дурдсан “Монголын язгуурын түүх оршил”, “Зохион бичих тухай захидал” гэх хоёр зохиолын дээр “Нэгэн давхар асар”-ыг хянан найруулагчийн оршил” “Эрт, эдүгээх Монголын үлгэр”-ийн угийн оршил”, “Улаан барс” сэтгүүл сэргээх дөрөвдүгээр хугацааны хэвлэлийн оршил”, “Улаан барс” сэтгүүл эх бичиг элсэн цуглуулах нь”, “Нигуны жүжиг” зэрэг зохиол

бүтээлүүдийг нь сийрүүлээд дөхөмхөн хавсарга тайлбар хийхээр дамжуулан Бөххишигийн утга соёлоо хөгжүүлэх зорилтыг тодорхойлохыг санаачлав.

2005 онд нийтлэгдсэн доктор У.Цахилалын “Улаан барс” сэтгүүл ба “Шинэ монгол” сэтгүүлийн нөлөө үйлдлийн тухай” [35] гэх өгүүлэлд “Улаан барс” сэтгүүл нь “Монгол утга соёлыг дэлхийн утга соёлын их зайд зам нийлүүлж ам залгуулах”, “Нэрт эрдэмтний зохиолыг уламжлан тэмдэглэх”, “Монголын эртний утгыг сүвэгчлэн нягтлах”, шүүмж өгүүлэхүйг хуримдуулах, орчин үеийн утга соёл ба утга зохиолын талбарыг үүдэн байгуулах зэрэг талаар чухал нөлөө үйлдэлтэй. “Улаан барс” нь бас “Аливаа сургаал

эрдмийг монгол хэл соёл хэмээх ганц тугийн дор идлэг бүлгэмдлүүлж идэвхтэй ажиллуулсан нь орчин үед ч, одоо үед ч ахуйч ач холбогдолтой болсон бөгөөд түүхт ач холбогдол ч орших юм” [35] гэх дэлхийн утга соёлын ам сээрийг залгуулсан гэдэг шинэвтэр үзэлтийг дурджээ. Мөн жилд докторант Отгонбаяр бээр “Орчин үеийн хэвлэлийн зүтгэлтэн Хээшингэ,

Бөххишиг нарын утга соёлын хөөцөлдөл” [36] гэх өгүүлэлдээ монгол утгын сургаалын хурал ба “Улаан барс”-д нийтлүүлж байсан ном зохиолын сэдэв сонголтыг “Хичээл хүмүүжлийн монгол хэл бичгийн хамаатай сэдэв”, “зан үйл, аман зохиолын сэдэв”, “Түүх, уран зохиолын сэдэв сонголт”, “Орчуулгын ном зохиолын сэдэв сонголт” гэх дөрвөн талаар задлан шинжиж,

эдгээр хэвлэлээс Бөххишигийн “Утга соёлоор угсаа аймгаа тэтгэн тэнхрүүлэх” гэсэн хөөцөлдлийг олж харж болно гэдэг үзэлтийг дэвшүүлэв. Үүнийг Бөххишигийн найруулахуй ажлын сэдэв сонголтын талаарх онцлогийг нарийсган тодорхойлсон анхдагч оролдлого гэж болно.

2007 онд нийтлэгдсэн Чин Чиүвэн, Тэхү дагуулын “Иргэн улсын үеийн монгол хэвлэгдэхүүний тараалтын байдал” [37] гэх өгүүлэл бол Бөххишигийн тухай хэвлэхүй ухааны үүднээс судалсан шинэ сэдэвлэхүүнтэй зохиол болно. Өгүүлэлд Монгол утгын сургаалын хурлын сонин сэтгүүл, ном бичгээ борлуулах аргыг “Монгол утгын сургаалын хурал” хэвлэгдэхүүндээ үнэ

«

*Монгол үндэстний орчин үеийн
үзэл санаа, утга зохиол, сурган
хүмүүжил хийгээд найруулахуй
хэвлэхүйн түүхнээ нөлөө ихтэй
соёлын зүтгэлтэн Бөххишиг ХХ
зууны хориод онд “Утга соёлоор
үндэстнээ тэтгэн тэнхрүүлэх”
зорилтоор “Монгол утгын
сургаалын хурал” гэх соёлын
нийгэмлэгийг үүсгэн байгуулсан ба
“Улаан барс”-ыг эрхлэн
найруулжээ.*

»

тогтоон худалдахаас гадна, "Урьдаар зоосоо тушааж бичиг худалдан авах урт болзооны дүрэм" ба "Урагш дармаллан гаргасан хэдэн зүйлийн хуучин бичгүүдийг шинэ бичгээр сольж авах" зэрэг тараалтын хэлбэртэй байсан" [38] гэж эзэгнэлт, тараалтын байдлыг анхдагч удаа тодруулав. Мөн жилд Сиүвэй Лиян бээр "Улаан барс" сэтгүүл хийгээд түүний монгол соёл, сурган хүмүүжилд үзүүлсэн гавьяа зүтгэл" [39] гэх өгүүллээ нийтлүүлсэн байна. Тус өгүүлэлд зохиогчоос Бөххишигийн "Монгол-хятад аялгууг хосолсон бичиг"-ийг нийтэлж байсан, шинэ үг, нэр томъёог орчуулан дүрэмжүүлж, тогтоон хэрэгжүүлсэн, ардын дууг өргөн хэмжээгээр цуглуулан эмхтгэсэн, сургууль байгуулсан, "Улаан барс" сэтгүүл дээр хавт үгс нийтэлж байсан зэрэг бодит ажиллагааг нь танилцуулж, түүний монгол соёл, сурган хүмүүжилд үзүүлсэн гавьяа зүтгэлийг үнэлжээ.

Үүнээс гадна 2000-2005 оны хооронд эл зүйлийн намтар тэмдэглэл [40], [41], [43], орон нутгийн ойллого [39], нэвтэрхий толь [42], [45], нэвтэрхий түүх [44], хэвлэгдсэн ба эдгээр бүтээлүүдэд Бөххишигийн тухай сураг зангийг адил бус хэмжээгээр үргэлжлүүлэн нийтэлсээр буй.

Гурав. Бөххишигийн тухай судалгааны ололт амжилт хийгээд орон зай

Дээр дурдсан зохиол бүтээлийг ажиглахад эрдэмтэд өөр өөрийн судлал шинжлэлийн хараашаасаа Бөххишигийн уран зохиолын үйлс, сурган хүмүүжлийн үйлс, найруулахуй хэвлэхүй үйлс, орчуулгын үйлс, чанагшлан зан үйл, эрүүл хамгаалал зэрэг бүхий л монгол соёлын үйлсэд үзүүлсэн гавьяа зүтгэлийг адил бус хэмжээгээр тодорхойлон үнэлсэн байна. Бөххишийн тухай судалгаа нэгэнт дөч гаруй жилийн түүхтэй болж, улмаар хүрээ цараагаа тэлж, шинжилгээний салаа

сундалсан хандшаар хөгжөөд зохих судалгааны суурьтай болсон боловч нарийсган гүнзгийрүүлэх орон зай маш өргөн байна. Бид Бөххишигийн тухай судалгааны ололт амжилт ба орон зайг доорх мэт хураангуйлав.

1. Бөххишигийн тухай судалгааны үйлсийг гадаадад эхэлсэн боловч дахин судлагдаагүй нь даанч харамсалтай явдал юм. (Үүнд нэг тодрууштай явдал бол Бөххишигийн "Монголын нууц товчоон"-г монгол үсгээр буулгасан тухай монгол улсын эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгээс "Өвөр Монголын сэхээтэн хүмүүс Нууц товчоог хятад хэл ба хятад сийрүүлгээс хэдэн удаа монгол үсгээр буулгаж хэвлүүлсэн юм. Жишээ нь Хишигбат, Бөххишиг, Алтан-Очир зэрэг хүмүүс "Нууц товчоо"-г монгол үсгээр буулгаж 1940 оны орчимд тус тус хэвлүүлжээ. Үүний дотроос хамгийн нягт сайн хийсэн нь Бөххишиг болно. Бусдынх нь орчуулга олигтой эрдэм шинжилгээний бүтээл болж чадаагүй. Зөвхөн сонирхогчдын бүтээл болжээ" [23:75] гэж үнэлсэн мэдээ байдаг. Гэхдээ Ц.Дамдинсүрэнгийн уг номыг олж үзээгүй).

2. Улсын дотоод дахь Бөххишигийн тухай судалгаа нь утга зохиолын хараашаас эхэлсэн бөгөөд энэ талын судалгаа одоо болтол хамгийн эрчимтэй үргэлжилсээр. 1981 оноос өнөө болтол Б.Гэрэлт, Ү.Шугар, Вэн Мандаа нарын туурвисан уран зохиолын түүх бичлэгийн ном ба Б.Сүхээ, У.Цахилал нарын тусгай сэдэвт өгүүлэл зохиол зэрэг арваад ном, өгүүллүүдэд бүр Бөххишигийн тухай утга зохиолын талаар судалгаа өрнүүлсэн юм.

3. Бөххишигийн тухай судалгаа олон шинжилгээний салаа сундалсан хандшаар хөгжөөд, одоо болтол хэл бичиг түүх, утга зохиол, найруулахуй хэвлэхүй, соёл сурган хүмүүжил, орчуулгын үйлс, зан үйл, эрүүл хамгаалал, нийгмийн хөдөлгөөн зэрэг хүрээнд холбогдуулан судалж байна. Үүнд хамгийн арвин бөгөөд нарийсгасан судалгаа бол утга зохиолын хүрээн дэх

судалгаа байж, хамаа бүхий ном, өгүүлэл, нэгэнт арваад хэвлэгдсэн ба хамгийн цөөхөн бөгөөд дурдалтын шинжтэй судалгаа бол орчуулга хийгээд эрүүл хамгааллын талаарх судалгаа болно. Төгсцогт, Вэн Сиү Лэн бээр "Улаан барс"-ын 1939 оны 4, 5, 6, 7, 8, 9, 10 дугаар тэмдэгтээ эрүүл хамгааллын мэдлэгийг нийтэлж байсан тухай цухас дурдаж [28:284], Б.Сүхээ бээр "Улаан барс"-ын эрүүл хамгааллын үйлс [32:462-474]-д үзүүлсэн нэмэр хандивыг анх удаа дурджээ. Үүнээс гадна Бөххишигийн "Аливаа сургаал эрдмийг монгол утга дээрээ дэлгэрүүлэх" зорилтоор монгол хэл бичгийн эрдэм шинжилгээний ажлыг өрнүүлж байсан тухай Б.Сүхээгээс ном, өгүүлэл [32], [20], [21]-дээ дурдсан юм. Гэхдээ эрдэмтэд Бөххишигийн "Улаан барс" сэтгүүлдээ нийтэлж байсан шинэ үг, нэр томъёоны орчуулга хийгээд орчуулгын зохиол нийтлэлийнх нь арга, онцлогийн тухай хараахан гүнзгий судалгаа өрнүүлэхгүй байсаар.

4. Бөххишигийн монгол найруулахуй хэвлэхүй үйлс дэх гавьяа зүтгэл нь товойм боловч энэ талаарх судалгаа нь харьцангуй хожуу эхлээд, улмаар нэмэгдсэн боловч судалгааны орон зайгаар хамгийн их байна. Бөххишигийн тухай судалгааны анхны шатанд монгол утгын сургаалын хурлаас хэвлэсэн ном ба "Улаан барс"-д нийтэлсэн зохиол бүтээлийг танилцуулахын дагуу Бөххишигийн монгол найруулахуй хэвлэхүй үйлс дэх гавьяа зүтгэлийг танилцуулж байжээ. XX зууны сүүлч ба шинэ зууны эхнээс эхлэн Бөххишигийн тухай судалгааны тусгаар сэдэвт ном, өгүүлэл туурвигдаж хэвлэгдсэн ба найруулахуй хэвлэхүй ухааны хараашаас ч тусгай сэдэвт судалгаа өрнүүлэх болжээ. Үүнд: Төгсцогт Вэн Сиү Лэн, Бүрээчин дархан, Отгонбаяр ба Жин Чиүвэн Тэхүдагуул нарын ном, өгүүлэл нь найруулахуй хэвлэхүй ухааны үүднээс судалсан юм. Бөххишигийн найруулахуй хэвлэхүй үйлсэд үзүүлсэн гавьяа зүтгэлийг нарийсган ширхэг-

жүүлж, гүнзгийрүүлэн судлах орон зай бас ч их байсаар юм. Жишээлбэл монгол утгын сургаалын хурал ба "Улаан барс"-ын эзэгнэлт хамааралтын арга, монгол утгын сургаалын хурлаас хэвлэсэн ном зохиол ба Бөххишиг өөрийнх нь найруулж хэвлүүлсэн зохиол бүтээлийг бүрэн гүйцэд тодлоогүй байсаар.

5. Бөххишигийн бичсэн оршил гаргалгаас түүний утга зохиолоо сэргээн хөгжүүлэх үзэл санааг сүвэгчилсэн судалгаа нилээд хангалттай болсон боловч эдгээр зохиол өгүүллээс нь Бөххишигийн найруулахуй хэвлэхүйн үзэлт зорилт, эзэгнэлт хамааралтын арга барилыг сүвэгчлэх талаар орон зай их байна. Жишээлбэл профессор Б.Гэрэлт, Вэн Мандаа нараас өөрийн номдоо Бөххишигийн бичсэн оршил гаргалгын зохиолоос түүний уран зохиолын тухай үзэлтэд сүвэгчлэл хийжээ. Гэхдээ Бөххишигийн бичсэн оршил гаргалгын зохиолоос түүний найруулахуй хэвлэхүйн үзэл санааг сүвэгчилсэн өгүүлэл бүтээл хараахан гараагүй юм.

Дөрөв. Бөххишигийн тухай судалгаан дахь нэгтгэн тодрууштай асуудлууд

1. Бөххишигийн тухай үнэлэлтийг эмхлэн нэгтгэх шаардлага

Өнгөрсний судалгааны бүтээлд Бөххишигийн тухай монгол утга соёлын өвийг хамгаалагч, шинэ соёлыг уриалагч, сурган хүмүүжлийн зүтгэлтэн, хэвлэлийн үйлсийн зүтгэлтэн [23], хэвлэхүй үйлсийн алдарт зүтгэлтэн бөгөөд найруулагч [11:96], алдарт сэтгүүлч, найруулагч, хэвлэгч болохоор үл барам сурган хүмүүжүүлэгч [25:1495], ойр орчин үеийн алдарт хэвлэн найруулагч, соёл хүмүүжлийн зүтгэлтэн [26:187], монгол үндэстний шинэ соёлын хошууч, монгол үндэстний орчин үеийн уран зохиолын үйлс, сурган хүмүүжлийн үйлсэд чухал хувь нэмэр үзүүлэгч [40:3138], орчин үеийн

соёлын зүтгэлтэн, алдарт эрдэмтэн [39:1011], шинэ соёлын зүтгэлтэн, найрууллын зохиолч [42:321], Соёлын зүтгэлтэн, найруулагч, орчуулагч [45:251], сурган хүмүүжил, хэвлэл дармалын үйлсийн зүтгэлтэн [43:298], шалгарсан эрдэмтэн, зохиолч нийгмийн хөдөлгөөнтөн [9], уран зохиолыг хөгжүүлэхэд идэвхтэй санаачлагч ба чадвартай зохион байгуулагч болжээ [8:288-289], монгол соёлын чин зоригт байлдагч мөн [11:101] зэрэг 12 зүйлийн үнэлэлт буй.

Дээрхийг хураангуйлбал, Бөххишигийг олон янзаар үнэлж байгаа нь Бөххишигийн нийгэм соёлын эл хүрээнд эрчимтэй ажилласныг харуулж байгаа юм. Үүнд (7 зохиолд) соёлын зүтгэлтэн (6 зохиолд) найруулахүй хэвлэхүй үйлсийн зүтгэлтэн, (5 зохиолд) сурган хүмүүжлийн зүтгэлтэн, (4 зохиолд) уран зохиолын зүтгэлтэн, (2 зохиолд) эрдэмтэн гэсэн бөгөөд ганц ганц зохиолд орчуулагч ба нийгмийн хөдөлгөөнтөн гэв. Эдгээр үнэлэлтээс Бөххишигийн нэг насны үйл ажиллагааны аль нь хамгийн гол болох ба аль аль үнэлэлт нь бодит байдалтай нь тохиролцох эсэхийг холбогдох шинжилгээний салааны үүднээс задлан шинжилж, хураангуйлан нэгтгэх чухалтай байна.

2. Монгол утгын сургаалын хурал ба "Улаан барс"-ыг эрхлэн байгуулсан цагийн тухай хэллэг, жич үзэлтийг нэгтгэх шаардлага

Өнгөрсний судалгааны бүтээлд монгол утгын сургаалын хурал ба "Улаан барс"-ыг эрхлэн байгуулсан цагийг 1927 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр, билгийн улирлын улаан барс жилийн сүүл сарын 20-ний өдөр [23:52], [41:55], [43:307], [44:736], билгийн улирлын 1926 оны 12 дугаар сарын 20-ний өдөр [26:188], нийтийн он тооллын 1926 он [27:300], 1927 оны 1 дүгээр сар [40:3138], Иргэн улсын 15 дугаар он (1926) он (13:131), 1926 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр (билгийн улирлын

улаан барс жилийн сүүл сарын хорин) [39:1010], 1927 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр [35], 1926 оны сүүлч [29], [42:321], 1927 он [37], [45:83], 1926 он (Улаан барс жил) [3], [32:1], 1926 оны 1 дүгээр сарын 23 [28:274], [30:216], 1926 он [8:286], [9], [10:402], [11:9], [16:117], 1928 он (Улаан барс жил) [1493], билгийн улирлаар 1926 оны 12 дугаар сарын 21-ний өдөр, аргын улирлаар 1927 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр [12], 1928 он [46:478] гэх мэтийн адил бусаар өгүүлсэн байна.

Түүхийн ухааны үүднээс сурвалж бичгийн тэмдэглэл хийгээд сурвалжлан байцаахыг уялдуулан байж, товч дэлгэрэнгүй нь тэгш хэмийн бус гурван оны доторх сар өдөр нь нэн ч зөрөөтэй эдгээр хэллэгийн зөв бурууг тодолж нэгтгэх чухалтай.

3. Бөххишигийн төрсөн он, сарын тухай адил бус хэллэгийг баримжаажуулах шаардлага

Өнгөрсний судалгаанд Бөххишигийн төрсөн он сарыг 1902 оны 5 дугаар сарын 23-ны өдөр [43:298], Чин улсын бадаргуулт төрийн 28 дугаар он (1902 он) [23:3], [45:298], Чин улсын бадаргуулт төрийн 28 он (1902 он) [9], [24], 1902 оны 5 дугаар сарын 13-ны өдөр [25:1492] гэх мэтийн адил бусаар өгүүлсэн байна.

Бөххишигийн төрсөн оныг бүр 1902 гэж байгаа боловч аргын улирал ба билгийн улирлын тавдугаар сарын аль өдөр болохыг тодруулах шаардлага буй.

4. Бөххишигийн нэрийн монгол хятад адил бус бичлэгийг тодолж нэгтгэх шаардлага

— Бөххишигийн монгол нэрийнх нь адил бус хятад бичлэгийг долоон зүйлээр бичиж байгаагийн аль нь түүний монгол үсгийг хятадчилах авиатай нь илүү тохиролцохыг нотолж нэгтгэх чухалтай.

— Бөххишигийн хятад нэрийнх нь адил бус монгол бичлэгийг Лиян Цүй

Лэн [43:298], [26:18], Лиян Цүй Лин [41:55], Лияан Цүй Сиүвэн [7:80], Лиаян Цүй Пен [24] гэж 4 зүйлээр бичиж байдаг.

— Бөххишигийн өргөсөн нэрийнх нь адил бус бичлэгийг Лияан Цүй Сиүвэн [24] [42:321], Лияан Цүй Сиян [41:55], Сүй Шүтэн [11:96] гэх мэтээр бичиж байдаг.

Иймэрхүү олон зүйлээр бичсэний хятад нэрийг монголоор бичсэн нь үнэнхүү дөрвөн хятад нэрийнх нь монгол бичлэг юм уу, эсхүл ташаа бичлэг үү? Бас 3, 4 дүгээр зурваст дурдсан өргөсөн нэр ба бичгийн нэр нь өөр өөр утгатай юу, аль эсхүл адил санааны адил бус хэллэг үү? Юунд иймэрхүү олон нэрийг хэрэглэж байсан шалтгаан зэргийг нь тодлууштай юм.

5. *Бөххишийн бичсэн оршлыг цуглуулан найруулахуй хэвлэхүй ухааны үүднээс задалж шинжлэх шаардлага*

Бөххишигийн тухай судалгааны бүтээлүүдэд “Монголын язгуурын түүхийн оршил” [2:353], [10:406], [23:232], “Улаан барс” сэтгүүлийн дөрөвдүгээр хугацааны оршил” [3], [26:190], “Монголын нууц товчоо”-ны оршил [23:22], [40:3139], “Япон улсын сургуулийг тойрон үзсэн өдөр бүрийн тэмдэглэл”-ийн оршил (2) [23:12-124] -ийн оршил [40:3139], “нэгэн давхар асар”-ыг хянан найруулагчийн оршил [34:645], “Эрт эдүгээх Монголын үлгэр”-ийн угийн оршил [34:647] зэрэг 7 зохиолыг нь эмхтгэн оруулсан байна. Эдгээр оршлыг хэзээ, ямар зорилгоос яаж бичсэнийг найруулахуй хэвлэхүй ухааны хараашаас нарийсган судлах чухалтай бөгөөд өөр бас ямар ямар оршил бичсэн эсэхийг нягтлах хэрэгтэй.

6. *Монгол утгын сургаалын хурлаас хэвлэсэн ном зохиолыг тодруулах шаардлага*

Олонх эрдэмтэн монгол утгын сургаалын хурлаас дөчөөд зүйлийн монгол ном бичиг хэвлэв гэж үзэцгээдэг. Үүнд Эрдэмт, Буянтогтохын “Бөххишиг

хийгээд түүний монгол утгын сургаалын хурал” гэх ном [23:356-359] ба бусад ном, өгүүлэлд дурдсаныг тодруулбал: “Монголын нууц товчоо”, “Монголын язгуурын түүх”, “Их Юан улсын мандсан төрийн хөх судар”, “Нэгэн давхар асар”, “Хи Хун Дэн”, “Нибфон улсын сургуулийг байцаан үзсэн өдөр бүрийн тэмдэглэл”, “Нибфон улсын шашин суртахууныг тойрон үзсэн өдөр бүрийн тэмдэглэл”, “Хөх Монголын хөх туг”, “Мигуйн туршигч”, “Гэтэлгэгч хорин нэгэн дарь эхийн мөргөл”, “Цагаан шүхэртийн магтаал”, “Билиг барамидын зүрхэн”, “Бу чин да сан”, “Хэлхээт сувд”, “Олон дуу, шүлэг”, “Чингис богдын сан”, “Шүй Хү бичиг”, “Эв найрамдах хурлын үгс”, “Эрт, эдүгээхийн бага үлгэр”, “Монголын шинэ толь”, “Зүрхэн толь”, “Монголын шинэ үлгэр”, “Хэлэн чимэг”, “Хар сүлдийн сан”, “Улаан барс”, Буяндэлгэр гэгч хүний бичсэн “Монгол хүний буянаараа гэгч үнэн үү?”, Ринчинхорлоогийн бичсэн “Гашууны доторх тэлчилэгч”, Бөх-Үндэсний англи хэлнээс орчуулсан “Ирвэсийн шимну” [5], “Үйлийн үр” [27:30], Алтан-Очирын орчуулсан “Монголын нууц товчоон” [2:353], “Монголын бага үлгэр” ба “Шинэ үгс” [30:385] зэрэг монгол утгын сургаалын хурлаас хэвлэсэн 31 номын гарчгийг тодруулан жагсаажээ. Бас арваад номыг тодлох чухалтай.

7. *Бөххишигийн өөрийнх нь найруулж хэвлүүлсэн ном зохиолуудыг бүртгэн тодруулах шаардлага*

Эрдэмтэд Бөххишигийн өөрийнх нь ном зохиолыг танилцуулахдаа “Монголын нууц товчоо”-г монгол үсгээр буулгасан, “Монголын язгуурын түүх”-ийг харуулсан тайлбарласан ба “Ниб-фоны шашин суртахууныг тойрон үзсэн өдөр бүрийн тэмдэглэл” [23:357], “Нибфоны сургуулийг байцаан үзсэн өдөр бүрийн тэмдэглэл” [30:357] -г бичсэн хийгээд “Хишигтний хэлмэрчийн үгс”, “Найманы хэлмэрчийн үг”, “Хавт үг” зэргийг эмхтгэн цуглуулс-

ныг үлэмж дурддаг. Эдгээрээс гадна "Зохион бичих тухай" [2:353], "Монгол утгын хураангуй дүрэм", "Хурлын гишүүдэд өгсөн захидал", "Монгол үсгээр өөрснөө зохиосон үлгэрийг шан гаргаж элсэх тухай мэдэгдэл" [26:192], "Улаан барс" сэтгүүлийн эх бичиг элсэн цуглуулах нь [34:650], "Сэн вэнгийн дуулал" гэх найруулал [29], "Дагалдуулан мэдэгдэх зүйлс" [23:364] зэрэг зохиол бүтээлийг нь зарим ном, өгүүлэлд ганц хоёроор дурдсан боловч, Бөххишигийн зохиол ба найруулсан бүх зохиолыг бүртгэн тодруулах шаардлага буй.

Үүнээс гадна бусадтай хамтран бичсэн "Шинэ нэрийг орчуулж тогтоохын учир" хийгээд "Шинэ нэрсийг орчуулж тогтоосны учир" мэтийн эрдэм судлагааны зохиол хэд байдгийг тодрууштай байна.

8. "Улаан барс" сэтгүүл дээр нийт хэдэн нэр томьёог ямар хэлнээс яаж орчуулсныг тодруулах шаардлага

Бөххишигийн тухай судалгааны бүтээлүүдэд нэр томьёоны орчуулгатай холбогдуулан өгүүлсэн ном, өгүүлэл тавхан байдаг. Үүнд хэдий хэр нэр томьёог орчуулсан тухай 1936 оноос 1938 он болтолх гурван жилийн хооронд шинэ нэрс 1100 гаруй зурвасыг тогтоон нийтлэв. [23:85] шинэ үг, нэр томьёог "Улаан барс" сэтгүүлийн 5 дугаар хугацааны аравдугаар тэмдэг болтол "нийт 500 илүү үг тогтоон" дүрэмжүүлэн нийтэлжээ. [32:15] "Улаан барс" сэтгүүл нь нийт 500 илүү үгийг тогтоон дүрэмжүүлэхийн дагуу сэтгүүлдээ нийтэлсэн байна. [38] гэдэг гурван зүйлийн дурдалт байдаг ба нэр томьёог ямар хэлнээс орчуулсан тухай "Монгол утгын сургаалын хурал" нь 1936 оноос аваад монгол хятад нэрсийг орчуулж эхэлжээ. 1937 оноос хойш монгол-хятад-япон гурван хэлний харьцуулсан орчуулгыг нийтлэх болов [23:83]. Тус сэтгүүл "Улаан барс"-ын тавдугаар хугацааны гуравдугаар тэмдэгт хятад

үсгээр тавин нэр үгийг нийтэлжээ [28:283]. Шинээр тогтоохыг хүлээж бүхий нэр томьёо хэмээн 16 хятад нэр томьёог жагсаасан байна [32:13-14]. Хятад хэлнээс үлэмж олон нэр томьёог эрдэмтэн чадвартадын санал зөвлөгөөгөөр нэгтгэн монголчилж байсан мөртөө харь хэл голдуу англи хэл, япон хэлнээс зохих тооны нэр томьёог хятад хэлээр дамжилгүй шууд хүлээн авч монголчилж байв [35]. Монгол, хятад, япон хэлний 1000 гаруй шинэ үг, нэр томьёоны орчуулгыг нийтэлжээ [47]. Гэвч "Улаан барс" сэтгүүлийн бүх дугаарыг олж, түүн дээр нийтэлсэн нэр томьёог бүгдийг шүүж, ямар хэлнээс нэр томьёог яаж орчуулж байсан тухай нарийсган судлах чухалтай.

9. "Улаан барс"-ыг эрхэлсэн хугацааг тодруулах шаардлага

"Улаан барс"-ыг Бээжинд 1927-1933 оны хооронд нийт гурван хугацаа эрхэлсний дараа хэдэн жил хэвлэл зогсож, дахиад Кайлуд хэвлэл сэргээж 1945 он болтол арван хугацаа хэвлэсэн гэж олонх эрдэмтэд үзэцгээдэг боловч Ёндон "Улаан барс"-ыг 1926 оноос эхлэн 1944 он хүртэл Бээжин, Кайлуд нийт арван хугацаа хэвлэв" [41:57] гэжээ.

10. "Улаан барс"-ын Кайлуд хэвлэл сэргээсэн оныг тодлох шаардлага

Өнгөрсний судалгаанд "Улаан барс"-ын Кайлуд хэвлэл сэргээсэн оны тухай гурван зүйлийн хэллэг буй. Эдгээрээс аль нь хамгийн оновчтой болохыг тодлох шаардлагатай. 1936 онд сэтгүүлээ үргэлжлэн гаргажээ. [5] [45:83] 1934 оны сүүлээр "Монгол утгын сургаалын хурал" нь Кайлуд нүүн ирж, үргэлжлэн ном бичиг тараах ба "Улаан барс"-аа дармаллан эхлэв. [24] 1935 онд Зүүн Монголын Кайлуд нүүлгэн ном сэтгүүл хэвлэх болжээ [10:402].

Эдгээрээс гадна Бөххишигийн тухай судалгааны бүтээлүүдэд зохиогчийн нарийн хянуур орсонгүйгээс болсон алдаа мадаг оршиж байдаг. Жишээл-

бэл: "Улаан барс" дээр англи хэлний "Economic" гэх үгийг "Их нэмэх" гэж монголчилсон гэжээ [35]. Үнэндээ "Улаан барс"-ын тавдугаар хугацааны дөрөвдүгээр тэмдгийн "гуравдугаар удааны тогтоож илтгэх нэрс нь"-д япон хэлний үгийг (уул англи хэлнийх нь дуудлага, утгын дагуу) "Их хэмэх" гэж орчуулсан юм. Бас жишээлбэл зарим зохиолд Хад шинээр "Бөххишигийн утга соёлоор угсаа аймгаа тэтгэн тэнхрүүлэх үйл ажиллагаа ба үзэл санааны тухай" гэх өгүүлэл туурвисан. Хад "Өвөр Монголын багшийн их сургууль" (хятад)-ийн 1989 оны 4 дүгээр хугацаанд нийтлэгдсэн гэж зүүлт хаджээ [23]. Гэвч мөн сэтгүүлийн мөн оны мөн дугаар дээр ийм өгүүлэл нийтлэгдээгүй юм. Эдгээрийг аван үзэхэд ялимгүй асуудал шиг боловч нэг судалгааны өгүүлэл зохиолд бол ингэх их төлөвийг утгасан зүйл байж болшгүй юм.

Хураангуйлбал Бөххишигийн тухай эдгээр судалгааны зохиол бүтээлийг эмхлэн задалж, олсон амжилтыг нь нотлон, орших асуудлыг нь тодруулах бол хожмын Бөххишигийн тухай судалгааг бүх талаар системтэй бөгөөд гүн давхаргын нарийсгасан судалгаа болгохын урьдал нөхцөл болно. Бөххишигийн тухай судалгаа голдуу утга зохиолын хүрээнд төвлөрч, бусад талаар бол намтарчлан танилцуулсан төдий анхан шатны байдал тодруулалтад зогсонгуйрсаар байна. Бас Бөххишигийн орчин үеийн монгол найруулахуй хэвлэхүй үйлсэд үзүүлсэн гавьяа зүтгэлийг нь бүрэн гүйцэд тодруулаагүй байна. Үүнээс гадна хамагчилсан нэрийн асуудал дээр дам материалд үндэслэснээс болсон эндүү тодорхойлолт хааяа харагдана. Иймээс холбогдох шинжилгээний салааны онол аргаар жолоодомж болгон орчин үеийн бүх Дундадын үзэл урсгалтай холбогдуулан анхдагч материалд суурилсан, нарийсгасан судалгааг шалавдан хийгүүштэй байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Хайссуз В. 1986. Монголын түүх ба соёл. (Авид, Отгон орчуулав.) Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.
2. Гэрэлт Б. 1981. Монгол зохиолчдын шүүмж өгүүллүүд (1721-1945). Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.
3. Эрдэнэтогтох. Бөххишиг хийгээд монгол утгын сургаалын хурал // "Монгол хэл бичиг", 1981 оны дөрөвдүгээр хугацаа.
4. Эрдэнэтогтох найруулав. 1983. Монгол үндэстний сурган хүмүүжлийн бичиг материалын эмхтгэл. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.
5. Сэцэнбаатар Б. Монгол үндэстний түүхэн дэх соёлын зүтгэлтэн — Бөххишиг хийгээд түүний соёлын ажиллагаа // "Улаан хадын өдрийн сонин", 1984.09.25.
6. Гэрэлт Б. 1985. Монгол зохиолын онолын чимэг. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.
7. Түймэр. 1987. Улс байгуулагдахаас өмнөх Өвөр Монголын газар орны сонин сэтгүүлийн магадалсан гарчиг. Өвөр Монголын номын сан.
8. Шугар У. 1987. Монгол үндэстний орчин үеийн уран зохиолын түүх. Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо.
9. Ринчингаваа. 1990. Монгол бичгийн соёлын түүхийн дурсгалт түүх. Өвөр Монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.
10. Одонхүлэг найруулав. 1990. Монгол үндэстний орчин үеийн цуут хүмүүс. Өвөр Монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.
11. Эрдэмбуян. "Монгол утгын сургаалын хурал" байгуулагдсан нарийн мэдээ // "Өвөр Монголын багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл", 1990 оны 2 дугаар хугацаа.
12. Зэн Юн Биюу. 1988. "Кайлу Сияны монгол утгын сургаалын хурал" // "Кайлу Сияны соёлын түүхийн материал" (Хоёрдугаар эмхтгэл).
13. Сүхээ Б. Бөххишигийн "Япон улсын сургуулийг тойрон үзсэн өдөр бүрийн тэмдэглэл"-ийн тухай // Зуу-Одын монгол үндэстний багшийн тусгай мэргэжлийн сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 1990 оны 3 дугаар хугацаа.
14. Сүхээ Б. Бөххишиг хийгээд түүний сурган хүмүүжлийн тухай үзэлт үйлдэлгэ //

"Өвөр Монголын өдрийн сонин", 1990.05.14.

15. Сүхээ Б. "Улаан барс" сэтгүүл хийгээд монгол хэл бичиг" // "Монгол хэл бичиг", 1990 оны 10 дугаар хугацаа.

16. Сүхээ Б. Бөххишиг, Ролгоржавын "Монгол хятад аялгууг хосолсон бичиг"-ийн тухай // "Монгол хэл бичиг", 1991 оны 4 дүгээр хугацаа.

17. Сүхээ Б. Хорчины орчин үеийн бичгийн зохиол хийгээд Кайлугийн монгол утгын сургаалын хурал // "Монголын судлал", 1993 оны 2 дугаар хугацаа.

18. Эрдэмт, Буянтогтох найруулан зохиосон. 1992. Бөххишиг хийгээд түүний монгол утгын сургаалын хурал. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.

19. Зүүн Монголын шалгарсан эрдэмтэн зохиолч, нийгмийн зүтгэлтэн – Бөххишиг // "Жирэмийн сонин", 1987.12.30.

20. Алтаншаа найруулав. 1993. Монголчуудын өчигдрийн мөр. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

21. Вэн Мандаа. 1996. Монгол уран зохиолын онол, шүүмжлэлийн түүхэн найруулал. (XVII-XX зууны эх). Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

22. Төгсцогт, Вэн Сиү Лэн. 1999. Монгол сонин сэтгүүлийн тойм. Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо.

23. Шугар Ү. Монгол шинэ соёлын зүтгэлтэн Бөххишиг // "Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан", 2000 оны 1 дүгээр хугацаа.

24. Бүрээчин Дархан. 2002. Дундад улсын сонин мэдээний түүхэн тойм. Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо.

25. Мөнх Б., Ган шан. Улаан барс, сэтгүүл хийгээд монгол ардын дууны цуглуулга // "Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан", 2002 оны 2 дугаар хугацаа.

26. Сүхээ Б. 2003. Бөххишиг хийгээд "Улаан барс" сэтгүүлийн тухай судлал. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.

27. Улаан. Бөххишигийн утга соёлоор угсаа үндэстнээ сэнхрүүлэх үзэлтийг дурсан өгүүлэх нь // "Өвөр Монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл", 2003 оны 5 дугаар хугацаа.

28. Гэрэлт Б. 2003. Монгол зохиолын онол өгүүлэхүйн өв шүүлт. Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо.

29. Цахилал У. "Улаан барс" сэтгүүл ба "Шинэ монгол" сэтгүүлийн нөлөө үйлдлийн тухай // "Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан", 2005 оны 2 дугаар хугацаа.

30. Отгонбаяр. Орчин үеийн хэвлэлийн зүтгэлтэн Хээшингэ, Бөххишиг нарын утга соёлын хөөцөлдөл // "Өвөр Монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл", 2005 оны 5 дугаар хугацаа.

31. Жин Чиүвэн, Тэхүдагуул. Иргэн улсын үеийн монгол хэвлэгдэхүүний тараалтын байдал // "Өвөр Монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл", 2007 оны 3 дугаар хугацаа.

32. Сиүвэй Лиян. "Улаан барс" сэтгүүл хийгээд түүний монгол соёл сурган хүмүүжилд үзүүлсэн гавьяа зүтгэл // "Дундад улсын монгол судлал", 2007 оны 5 дугаар хугацаа.

33. Ёндон. 2004. Өвөр Монголын монгол судлалын зуун жилийн зуун хэрэг. Өвөр Монголын сурган хүмүүжүүлийн хэвлэлийн хороо.

34. 2002. Монгол судлалын нэвтэрхий толь (Утга зохиолын боть). Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

35. Зэн Лиү Жин, Бүрэнбаяр. 2005. Хорчин алдарт хүмүүс. Өвөр Монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.

36. 2002. Монгол судлалын нэвтэрхий толь (Сонин мэдээ, хэвлэлийн боть). Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

37. Алтаншаа На. найруулав. 1998. Өв соёлын өрлөг дархад. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

Summary

The thesis concluded the Buhehesik's editing and publishing activities from the leader which possessed the chief editor quality and the excellent entrepreneur that proficient in press operation and management. The Buhehesik's thought of the editing and publishing was reflected following four aspects: persisting in editing books by Mongolian, advocating the freedom of the press, committed to publish classic publications, pay attention to the value and novelty of the work etc.